

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын ГЭРЧИЛГЭЭ.....	3
2	Аудитын ТАЙЛАН	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
	2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
	2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
	2.12. Шилэн дансны мэдээлэл	10
	2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
	2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	11
4	АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	13
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5	АУДИТ ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ
СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Н.ЦОГЗОЛМАА
ТАНАА

2020.02.27 № 06/614
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй дүгнэлт

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Н.Цогзолмаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах, төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас эм, эмнэлгийн бүтээгдэхүүн хуваарилах тушаал шийдвэрийг цаг хугацаанд нь гаргаж, төслийн үр дүнг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төслийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн зохицуулагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Э.Цэрэннадмид хариуцаж хэрэгжүүлэв.

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 20/34 дугаар бүхий албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

НҮБ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннаны санаачлагаар ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх Глобаль санг 2002 онд байгуулсан бөгөөд төлөөлөгчийн газар нь Женев хотод байрладаг. Глобаль сан эдийн засгийн хувьд бага, дунд орлоготой орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ тухайн улсын Засгийн газраас зарцуулж буй төсөв, хөрөнгө дээр нэмэлт санхүүжилт олгох, үр дүнд тулгуурласан санхүүжилт хийх зарчмыг баримталдаг.

Монгол Улс 2003-2017 онд ДОХ, Сүрьеэ, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр нийт 57.9 сая ам долларын буцалтгүй тусламж авсан. Үүнээс 31.9 сая ам долларыг Сүрьеэгийн хөтөлбөрт зарцуулсан байна.

Монгол Улс, Глобаль сангийн хооронд 2015 оны 03 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан Хамтын ажиллагааны зарчмын тухай гэрээний дагуу Эрүүл мэндийн яам нь Глобаль сангийн санхүүжилтээр “Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих замаар тус өвчинтэй тэмцэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өвчтөн төвтэй нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж, хэвшүүлэх, эмийн дасалтай сүрьеэгийн аюул, эрсдэлд анхаарал хандуулж ажиллах” 7.2 сая ам долларын санхүүжилттэй MNG-T-MON хөтөлбөрийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2020 оны эцэс гэхэд үр дүнтэй эмчилгээний хувь хэмжээг 2015 оныхоос 90 хувь хүртэл өсгөж, сүрьеэтэй холбоотой нас баралтыг 30 хувиар бууруулах зорилготой ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сүрьеэгийн тусламж үйлчилгээ ба урьдчилан сэргийлэлт
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тусламж үйлчилгээ
- Сүрьеэ, ХДХВ хавсарсан халдварын тусламж үйлчилгээ
- Эрүүл мэндийн мэдээллийн системийн менежмент ба хяналт шинжилгээ үнэлгээ
- Хөтөлбөрийн менежмент
- Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн менежментийн тогтолцоо
- Цогц тусламж үйлчилгээ үзүүлэх, чанарыг сайжруулах
- Эрүүл мэндийн болон олон нийтийн хүний нөөцийг бэхжүүлэх

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Юникус программ хангамж ашигладаг байна.

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны үйл ажиллагааны батлагдсан төсвийн гүйцэтгэлээр сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,868,742.1 мянган төгрөгөөс тооцон **117,374.8** мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг **125,205.3** мянган төгрөгөөр тооцсон нь төсвийн гүйцэтгэлийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,018,034.0 мянган төгрөгөөр буюу 59.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж төлсөн зардал, бараа материал, богино хугацаат өр төлбөрийн дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,620,858.6	1,151,952.3	(468,906.30)
Авлага	1,057,108.4	2,039,133.6	982,025.2
Урьдчилж төлсөн зардал	68,919.8	151,027.4	82,107.6
Бараа материал	20,122.8	3,445,874.7	3,425,751.9
Үндсэн хөрөнгө	13,783.1	11,988.7	(1,794.4)
Биет бус хөрөнгө	1,725.0	575.0	(1,150.0)
Нийт хөрөнгө	2,782,517.7	6,800,551.7	4,018,034.0
Богино хугацаат өр төлбөр	151,275.4	1,327,579.2	1,176,303.8
Хуримтлагдсан үр дүн	2,631,242.3	5,472,972.5	2,841,730.2
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,782,517.7	6,800,551.7	4,018,034.0

Авлага дансны үлдэгдэл өссөн нь гадаад ханган нийлүүлэгч байгууллагаас тайлант оны захиалгатай 2,021,597.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй, нийт хүн амд сүрьеэ өвчнөөс сэргийлэх мэдээлэл сурталчилгаа хийх ажлын тендер арван нэгдүгээр сард явагдаж, сурталчилгааны ажлын урьдчилгаа төлбөр 15,020.0 мянган төгрөгийг 12 дугаар сард төлсөн, түргэн муудах чанарын хангамжийн зүйл авахаар төлсөн 2,516.3 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрүүд гарсантай холбоотой байна. Авлагын үлдэгдлүүдийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлагнасан.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл өссөн нь хоёр салбар хүлээн авагчийн бүрэн хэрэгжээгүй хөтөлбөрийн гүйцэтгэлтэй холбоотой байна. Эрүүл мэндийн яам Азийн хөгжлийн банктай “Вирус гепатит, сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлгийг сайжруулах” 9438-МОН төсөл хамтран хэрэгжүүлэхээр 2019 онд 500,000 ам долларын санхүүжилтийн гэрээ байгуулан тайлант онд 221,999.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үүнээс хэрэгжилт 37 хувьтай, санхүүжилтийн үлдэгдэл 140,432.4 мянган төгрөг, Халдварт өвчнөөс сэргийлэх үндэсний төвөөс Ерөнхий боловсролын сурагчдын дунд сүрьеэ өвчнийг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг хийх ажил хойшлогдсон, сүрьеэгийн резидент эмч бэлтгэх сургалтын урамшуулалт цалин олгогдоогүйгээс 10,595.0 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Урьдчилгаа төлбөрүүдийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь төслийн нэгж 2019 оны 9 дүгээр сараас хойш хүлээн авсан тусламжийн эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг захиалгын дагуу салбар хүлээн авагчдад хуваарилах жагсаалтыг бэлтгэн Эрүүл мэндийн сайдын тушаал гаргуулахаар хүргүүлсэн боловч 903,328.6 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг хуваарилан түгээх тушаал гараагүйтэй холбоотой байна. Эм, эмнэлгийн бүтээгдэхүүний жилийн эцсийн тооллого хийгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өссөн нь гадаад ханган нийлүүлэгч байгууллагаас урьдчилан нийлүүлсэн эм, эмнэлгийн бүтээгдэхүүний тооцоо 24,599.4 мянган төгрөг, Глобаль сангаас олгосон урьдчилгаа санхүүжилтийн 1,302,979.7 мянган төгрөгийн өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Монгол Улс, Глобаль сангийн Хамтын ажиллагааны зарчмын тухай гэрээний дагуу 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх MNG-T-MON хөтөлбөрийн хугацаанд 2,374.82 гэсэн дундаж ханшийг баримтлахаар зааж өгснийг төсвийн бүртгэлд баримталдаг.

Тайлант онд 2,471,236.61 ам доллар буюу 5,868,742.1 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар баталжээ.

Глобаль сангаас 2,142,962.7 мянган төгрөгийг мөнгөөр, 3,623,269.9 мянган төгрөгийн эм, эмийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн тусламжийн барааг гадаад ханган нийлүүлэгч байгууллагад шууд төлбөрөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт дүнгээр батлагдсан төсвөөс 391,521.3 мянган төгрөгийн хэтрэлттэй зарцуулсан нь төсвийг дундаж ханшаар тайлагнасан нь нөлөөлсөн байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж, нийт 24 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 6,508,346.6 мянган төгрөгийн алдаа илэрснээс 6,508,346.6 мянган төгрөгийн алдааг залруулж, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас эм, эмнэлгийн бүтээгдэхүүнийг хуваарилах тушаал шийдвэрийг цаг хугацаанд нь гаргаж төслийн үр дүнг сайжруулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 асуудлаар зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 3 асуудлаар нийт 6,508,346.6 мянган төгрөгийн алдааг залруулан тайлагнасан. Үүнд:

1. Төслийн 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилтийн орлогыг 342,530.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан,
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсөв, гүйцэтгэлийг зэрэгцүүлэн тайлагнаагүй, Глобаль сангаас гадаад ханган нийлүүлэгч байгууллагад шууд төлбөрөөр хийгдсэн тусламжийн эм, эмнэлгийн бүтээгдэхүүний 3,623,269.9 мянган төгрөгийн санхүүжилт, зарцуулалтыг тайлагнаагүй,

3. Салбар хүлээн авагчдад хуваарилсан эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж 2,542,546.1 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар тайлагнасан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрүүл мэндийн яам Азийн хөгжлийн банкт хамтран “Вирус гепатит, сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлгийг сайжруулах” 9438-МОН төслийг хэрэгжүүлэхээр 2019 онд 500,000 ам долларын санхүүжилтийн гэрээ байгуулсан. Тайлант онд 221,999.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 37 хувийн гүйцэтгэлтэй, санхүүжилтийн үлдэгдэл 140,432.4 мянган төгрөг байна. Иймд салбар хүлээн авагчдын мөнгөн урьдчилгааны тайланг хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлантай харьцуулах, үндсэн хүлээн авагчийн хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 101 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 582,262.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанаас 462,114.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 120,147.6 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд, зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт:

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурьдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тусламжаар хүлээн авсан эм, эмнэлгийн бүтээгдэхүүнийг хуваарилах үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд хүлээн авсан эм, эмнэлгийн бүтээгдэхүүнүүдийг захиалгын дагуу салбар хүлээн авагчдад хуваарилан түгээх үйл ажиллагаа удаашралтай, жилийн эцэст хуваарилагдаагүй 903,328.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн бүтээгдэхүүний үлдэгдэлтэй байна. Төслийн ханган нийлүүлэлтийн мэргэжилтнүүд 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс хойш ирсэн хэд хэдэн удаагийн татан авалтын барааг хуваарилах жагсаалтыг нэгтгэн ЭМЯ-д 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн боловч тушаал батлагдаж гараагүй байна.

1.2 Эрсдэл:

Цаг хугацаандаа бараагаа хуваарилаагүйгээс агуулахын хадгалалтын төлбөр нэмэгдэж үргүй зардал гарах, лавлагаа лабораториудын урвалж бодис, оношлууруудын нөөц дуусах, зарим хадгалалтын богино хугацаатай бараануудын хүчинтэй хугацаа багасах, тэдгээр бараануудыг хэрэглэж дуусахгүй устгах

1.3 Өгсөн зөвлөмж:

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах бүртгэх, тайлагнах журам”-ын

9.1.15-д “гадаадын тусламжийн хөрөнгөөр нийлүүлэх бараа, ажил, үйлчилгээ болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлын даалгаврын биелэлтийг дүгнэж, баталгаажуулах” гэсний дагуу тусламжийн барааг хуваарилах, түгээх ажиллагааг хурдан шуурхай гүйцэтгэхэд удирдлагаар хангах, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч залруулна.

2. Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт

Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилтийн орлогыг мөнгөн сууриар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

2.2 Эрсдэл

Глобаль сангаас тайлант жилийн зарцуулалтыг хянаж, санхүүжилтийн орлогыг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэлтэй зөрүүтэй тайлагнах нь орлого ба зардал зохицож байх зарчмыг хэрэгжүүлэхгүй байх.

2.3 Өгсөн зөвлөмж

Глобаль санд тайлагнадаг жилийн санхүүжилт, зарцуулалтын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайланг ижил тайлагнаж байх, цаашид 2017 оны Санхүүгийн менежментийн гарын авлагад нийцүүлэн санхүүжилтийн орлогыг бүртгэж, тайлагнах, алдааг давтан гаргахгүй ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хүлээн авч байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	1,620,858,619.95	1,151,952,344.54
310202	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	1,620,858,619.95	1,151,952,344.54
33	АВЛАГА	1,057,108,430.59	2,039,133,627.54
330500	Бусад авлага	1,057,108,430.59	2,039,133,627.54
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТООЦОО	68,919,773.18	151,027,419.57
340702	Урьдчилж гарсан зардал	68,919,773.18	151,027,419.57
35	БАРАА МАТЕРИАЛ	20,122,818.16	3,445,874,710.85
350400	Хангамжийн материал	20,122,818.16	3,445,874,710.85
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,767,009,641.88	6,787,988,102.50
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
3902	Биет хөрөнгө	13,783,085.84	11,988,590.80
390202	Автотээврийн хэрэгсэл	40,280,000.00	-
390202	Хуримтлагдсан элэгдэл	(40,280,000.00)	-
390203	Машин, тоног төхөөрөмж	66,388,402.61	42,938,023.73
390203	Хуримтлагдсан элэгдэл	(54,375,891.74)	(33,880,361.21)
390204	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,359,681.21	7,215,542.23
390204	Хуримтлагдсан элэгдэл	(15,589,106.24)	(4,284,613.95)
3903	Биет бус хөрөнгө	1,725,000.10	575,000.14
390301	Програм хангамж	4,600,000.00	4,600,000.00
390301	Хуримтлагдсан элэгдэл	(2,874,999.90)	(4,024,999.86)
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,508,085.94	12,563,590.94
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,782,517,727.82	6,800,551,693.44
41	Богино хугацаат өр төлбөр	-	-
410306	Бусад өглөг	151,275,430.91	24,599,432.79
	Бусад урьдчилж орсон орлого	-	1,302,979,764.11
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	151,275,430.91	1,327,579,196.90
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	151,275,430.91	1,327,579,196.90
	ЭЗНИЙ ӨМЧ	-	-
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
510200	Хуримтлагдсан үр дүн	2,631,242,297.01	5,472,972,496.54
510201	Өмнөх үеийн үр дүн	2,631,242,297.01	3,209,036,027.36
510202	Тайлант үеийн үр дүн	-	2,263,936,469.18
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,631,242,297.01	5,472,972,496.54
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,782,517,727.92	6,800,551,693.44

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,117,913,972.60	6,269,758,290.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,117,913,972.60	6,153,733,135.46
120	Нийтлэг татварын бус орлого	3,188,524,940.16	2,530,463,208.82
120002	Хүүгийн орлого	13,405,399.56	-
1200043	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,163,310,595.29	2,485,493,315.92
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,558,632.71	44,969,892.90
120009	Бусад орлого	2,250,312.60	-
122	Тусламжийн орлого	2,929,389,032.44	3,623,269,926.64
122002	Хандив тусламж/гадаад	2,929,389,032.44	3,623,269,926.64
13	ТАСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	116,025,154.67
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	116,025,154.67
131006	Засгийн газрын тусгай сангаас	-	116,025,154.67
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	7,708,625,097.03	3,974,165,604.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,708,625,097.03	3,974,165,604.01
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,708,625,097.03	3,858,140,449.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	925,668,146.99	870,607,829.61
210101	Цалин	925,668,146.99	870,607,829.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,889,793.04	42,243,554.34
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	36,889,793.04	42,243,554.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,499,932.44	112,481,122.10
210301	Гэрэл цахилгааны зардал	1,190,709.44	2,063,305.36
210203	Цэвэр, бохир усны зардал	-	1,349,874.74
210304	Байрны түрээс	126,309,223.00	109,067,942.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,231,752.13	125,305,868.82
210401	Бичиг хэрэг	10,919,400.00	9,034,903.26
210402	Тээвэр, шатахуун	12,167,749.72	25,176,908.75
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,983,961.41	7,150,146.41
210404	Ном, хэвлэл	10,797,000.00	60,608,099.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	25,363,641.00	23,335,810.41
2105	Нормативт зардал	5,316,652,718.74	1,356,818,925.24
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,272,043,952.74	1,323,225,925.24
210502	Хоол, хүнс	44,608,766.00	33,593,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,559,587.00	179,888,987.18
210604	Урсгал засвар	166,559,587.00	179,888,987.18
2107	Томилот, зочны зардал	192,309,802.80	307,510,033.17
210701	Гадаад албан томилот	-	-
210702	Дотоод албан томилот	157,322,673.00	307,510,033.17
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	34,987,129.80	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	131,365,095.93	81,608,723.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлч-ний төлбөр, хураамж	105,724,000.00	53,020,609.15
210802	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	25,000,000.00	28,181,818.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,600.00	406,296.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	281,495.93	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	747,448,267.96	781,675,405.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	199,802,998.00	291,363,952.90
210902	Сургалт семинарын зардал	536,889,834.40	482,549,230.65
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,755,435.56	7,762,222.18
213	Урсгал шилжүүлэг	-	116,025,154.67
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	116,025,154.67
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(1,590,711,124.43)	2,295,592,686.12
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	106,817,965.81	47,978,859.33
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз	106,817,965.81	47,978,859.33
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	130,486,372.49	79,635,076.27
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	130,486,372.49	25,106,550.66
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	54,528,525.61
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(1,614,379,531.11)	2,263,936,469.18

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,179,062,828.60	2,150,605,784.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,179,062,828.60	2,150,605,784.81
120	Нийтлэг татварын бус орлого	3,179,062,828.60	2,150,605,784.81
120002	Хүүгийн орлого	13,405,399.56	7,643,082.86
1200043	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,163,310,595.29	2,142,962,701.95
120009	Бусад орлого	2,346,833.75	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	2,522,626,621.82	2,632,175,758.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,522,626,621.82	2,632,175,758.68
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,522,626,621.82	2,632,175,758.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	925,668,146.99	865,382,670.70
210101	Цалин	925,668,146.99	865,382,670.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,889,793.04	42,243,554.34
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	36,889,793.04	42,243,554.34
2103	Тогтмол зардал	127,566,049.44	112,553,522.10
210301	Гэрэл цахилгааны зардал	1,190,709.44	2,063,305.36
210303			1,349,874.74
210304	Байрны түрээс	126,375,340.00	109,140,342.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,727,374.13	125,848,538.68
210401	Бичиг хэрэг	10,901,400.00	8,369,907.26
210402	Тээвэр, шатахуун	12,167,749.72	25,176,908.75
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,829,570.41	7,150,146.41
210404	Ном, хэвлэл	10,797,000.00	60,608,699.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	27,031,654.00	24,542,876.27
2105	Нормативт зардал	70,242,409.09	36,217,160.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,937,409.09	3,625,160.00
210502	Хоол, хүнс	43,305,000.00	32,592,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	168,309,487.00	179,888,987.18
210601	Багаж, техник хэрэгсэл	1,749,900.00	-
210604	Урсгал засвар	166,559,587.00	179,888,987.18
2107	Томилолт, зочны зардал	192,409,841.80	287,516,095.00
	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	157,422,712.00	287,516,095.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	34,987,129.80	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	131,127,695.93	94,009,573.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,486,600.00	64,771,709.15
210802	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	25,000,000.00	28,181,818.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,600.00	583,296.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	281,495.93	472,750.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	804,685,824.40	888,515,657.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,515,103.00	445,443,364.90
210902	Сургалт семинар	604,170,721.40	443,072,292.26
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	656,436,206.78	(481,569,973.87)

Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	-	4,817,727.18
22	Хөрөнгийн зардал	-	4,817,727.18
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан	-	4,817,727.18
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(4,817,727.18)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ Д	103,661,631.99	17,481,425.64
145	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАГЫН ДҮН	3,156,333.82	1,062,208.98
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	3,156,333.82	1,062,208.98
24	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	106,817,965.81	18,543,634.62
145001	Гадаад валютын ханшийн бодит бус олз	106,817,965.81	18,543,634.62
580	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	760,097,838.77	(468,906,275.41)
582	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	860,760,781.18	1,620,858,619.95
584	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,620,858,619.95	1,151,952,344.54

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын капитал	Хуримтлагдсан ҮР ДҮН	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	4,245,621,828.12	4,245,621,828.12
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			-
3	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		(1,614,379,531.11)	(1,614,379,531.11)
4	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	2,631,242,297.01	2,631,242,297.01
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		577,793,730.35	577,793,730.35
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		3,209,036,027.36	3,209,036,027.36
7	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			-
8	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			-
9	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		2,263,936,469.18	2,263,936,469.18
10	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл		5,472,972,496.54	5,472,972,496.54

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,620,858,619.95		
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,868,742,126.16	6,260,263,412.50	(391,521,286.34)	106.67
	УРСГАЛ ЗАРДАЛ	5,868,742,126.16	6,255,445,685.32	(386,703,559.16)	106.59
	Цалин хөлс болон ажил олгогчийн нийгмийн даатгалын зардал	916,634,211.01	907,626,225.04	9,007,985.97	99.02
	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	875,264,846.61	865,382,670.70	9,882,175.91	98.87
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,369,364.40	42,243,554.34	(874,189.94)	102.11
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,450,000.00	112,553,522.10	896,477.90	99.21
	Гэрэл цахилгаан	2,100,000.00	2,063,305.36	36,694.64	98.25
	Цэвэр бохир усны зардал	1,350,000.00	1,349,874.74	125.26	99.99
	Байрны түрээс	110,000,000.00	109,140,342.00	859,658.00	99.22
	Хангамж, бараа материалын зардал	126,228,699.99	125,848,538.88	380,161.11	99.70
	Бичиг хэрэг	8,500,000.00	8,369,907.26	130,092.74	98.47
	Тээвэр, шатахуун	25,320,000.00	25,176,908.75	143,091.25	99.43
	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	7,200,000.00	7,150,146.61	49,853.39	99.31
	Ном хэвлэл	60,608,699.99	60,608,699.99	-	100.00
	Бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлс	24,600,000.00	24,542,876.27	57,123.73	99.77
	Нормативт зардал	3,187,098,041.96	3,659,487,086.64	(472,389,044.68)	114.82
	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,144,588,763.96	3,626,895,086.64	(482,306,322.68)	115.34
	Хоол хүнс	42,509,278.00	32,592,000.00	9,917,278.00	76.67
	Эд хогшил, урсгал засварын зардал	210,599,037.60	179,888,987.18	30,710,050.42	85.42
	Урсгал засвар	210,599,037.60	179,888,987.18	30,710,050.42	85.42
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,314,732,135.60	1,270,041,325.48	44,690,810.12	96.60
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,314,732,135.60	1,270,041,325.48	44,690,810.12	96.60
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,817,727.18	(4,817,727.18)	
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		4,817,727.18	(4,817,727.18)	
	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз		(1,062,208.98)	1,062,208.98	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	5,773,875,711.45		
	Глобаль сангаас санхүүжих		2,142,962,701.95		
	Шууд төлбөр /Глобаль сангаас гуравдагч этгээдэд шилжүүлсэн дүн/		3,623,269,926.64		
	Хүүгийн орлого		7,643,082.86		
	Тохируулсан орлогын дүн	-	18,543,634.62		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,620,858,619.95		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,151,952,344.54		
	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
	АЖИЛЛАГСАДЫН ТОО		11		
	Удирдах ажилтан		1		
	Гүйцэтгэх ажилтан		10		
	Үйлчлэх ажилтан		0		
	Гэрээт ажилтан		6		

5 Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын н нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/48/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Глобаль сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төсөл			Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр	
А	З	4	5	8	9	
1	Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилтийн орлогыг мөнгөн сууриар тайлагнасан алдааг жил бүр давтан гаргасан.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	Н.Цогзолмаа Б.Бадамчимэг	
2	Төслийн нэгжээс 2019 оны 9-р сараас хойш ирсэн тусламжийн барааг хуваарилах жагсаалтыг хийж ЭМЯ-нд 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хүргүүлсэн ч тушаал гараагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	Н.Цогзолмаа Б.Бадамчимэг	
Нийт дүн		-				

